



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠨ
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ
ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ


БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2023 7 сар










www.ubstat.mn

[www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс](https://www.facebook.com/Багануур-дүүргийн-Статистикийн-хэлтэс)

www.1212.mn



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2019-2023 ОН	3
 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	8
 ГЭМТ ХЭРЭГ	9
 ҮНЭ ХАНШ	13
 АЖ ҮЙЛДВЭР	16
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2022 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	170805	37109	6214	34590	55283	37609
Үүнээс:						
Тэмээ	54	32	-	20	2	-
Адуу	15545	4115	634	3424	3804	3568
Үхэр	16278	4162	1182	3450	3843	3641
Хонь	84995	17874	2270	17162	29866	17823
Ямаа	53933	10926	2128	10534	17768	12577

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний VII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 I-VII	2020 I-VII	2021 I-VII	2022 I-VII	2023 I-VII
Суурин хүн ам	тоо	29 663	29 342	29433	29341	
Төрөлт	тоо	332	357	353	309	327
Нас баралт	тоо	72	82	84	106	84
Шилжиж ирсэн	тоо	283	214	696	359	378
Цэвэр өсөлт	хувь	0.88	0.93	0.92	0.69	0.83'

'суурин хүн амын тооноос тооцов.

1 – 2022 оны хүн амын тоо

2 - Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр хязгаарласан Нийслэлийн Засаг даргын захирамжийн хугацаа дууссантай холбоотой шилжилт хөдөлгөөний бүртгэл нэмэгдсэн.

ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, 2022 ОН






БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2023 оны 7 сарын эцэст 77 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 40 (34.2%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН, VII сарын байдлаар




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 7 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 42 (28.6%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, ШАЛТГААНААР, VII сарын байдлаар



Тайлант хугацаанд хугацаанд ажилд зуучлуулан орсон иргэн байхгүй байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 19 (24.7%) нь 15-24 насны, 25 (32.5%) нь 25-34 насны залуучууд, 18 (23.4%) нь 35-44 насныхан, 11 (14.3%) нь 45-60 насныхан, 4 буюу 5.2% нь 60-аас дээш насныхан эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, VII сарын байдлаар

Үзүүлэлт	Ажилгүйдлийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2022 VII	2023 VII	2022 VII	2023 VII
Ажилгүйдчүүд, бүгд	117	77	65	42
Үүнээс:				
Дээд боловсролтой	27	21	17	16
Тусгай дунд боловсролтой	3	2	1	1
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	18	13	9	4
Ерөнхий боловсролтой	66	41	36	21
Бага болон боловсролгүй	3	-	2	-

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 21 (27.3%) нь дээд боловсролтой, 2 (2.6%) нь тусгай дунд боловсролтой, 13 (16.9%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 35 (45.5%) нь ерөнхий боловсролтой ажээ. Ажил хайгч иргэдийн 42 (54.5%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 30.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 18.5 (1.6 дахин) тэрбум төгрөгөөр, зарлага 26.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.4 (25.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 24.0 (79.5%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 1.2 (3.9%) төгрөг тэтгэмжийн сангаас, 1.6 (5.4%) тэрбум төгрөг ҮОМШӨ сангаас, 2.8 (9.3%) тэрбум төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 585.4 (1.9%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний VII сард

Үзүүлэлт	2022	2023	Өсөлт бууралт	
	I-VII	I-VII	тоо	хувь
	сая төгрөг			
Сангийн орлого, бүгд	11 585.8	30 100.8	18 515.0	159.8
тэтгэврийн сан	7 690.8	23 925.0	16 234.2	211.1
тэтгэмжийн сан	774.0	1 159.6	385.6	49.8
ажилгүйдлийн сан	163.7	585.4	421.7	257.6
ҮОМШӨ ¹ -ний сан	910.7	1 639.1	728.4	80.0
ЭМД ² -ын сан	2 046.6	2 791.7	745.1	36.4
Сангийн зарлага, бүгд	20 980.8	26 398.0	5 417.2	25.8
тэтгэврийн сан	18 771.1	23 153.5	4 382.4	23.3
тэтгэмжийн сан	733.3	1 067.6	334.3	45.6
ҮОМШӨ-ний сан	1 096.6	1 610.4	513.8	46.9
Ажилгүйдлийн сан	379.8	566.5	186.7	49.2

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, сая төгрөг



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4909 хүнд 23.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 1814 хүнд 1.0 тэрбум төгрөгийн тэтгэмж, 401 хүнд 1.6 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 162 хүнд 566.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах талаар тусгасан. Үүний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг бүхэлд нь цахимжуулж дүүрэгт санхүүжилт хуваарилалт хийгдэхгүй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нэг данснаас зарцуулалт хийгдэж байна.

¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

² Эрүүл мэндийн даатгал

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний VII сард

Үзүүлэлт	2022		2023		<u>2023.VII</u>	<u>2023.I-VII</u>
	VII	I-VII	VII	I-VII	2022.VII	2022.I-VII
	сая төгрөг				хувь	
Сангийн зарлага	2855.7	11 335.1	2 090.1	10 188.7	73.2	89.9
Тэтгэвэр	248.6	998.3	143.4	909.0	57.7	91.1
Тэтгэмж	67.9	272.0	98.4	309.2	144.9	113.7
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	57.4	230.1	34.9	239.4	60.8	104.0
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	-	117.8	-	113.7	-	96.5
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	0.8	166.6	0.3	171.8	37.5	103.1
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	16.9	64.7	6.8	52.8	40.2	81.6
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	2 079.7	8 253.5	1 692.3	7 388.3	81.4	89.5
0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж	112.0	454.1	52.2	368.3	46.6	81.1
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	198.5	252.1	24.7	91.7	12.4	36.4
ХБиргэнд үзүүлсэн Хөнгөлөлт	11.8	28.4	4.8	21.5	40.7	75.7
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	30.3	126.5	13.0	94.0	42.9	74.3
Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж	1.4	41.3	-	66.8	0.0	161.7
ОНО-д түшиглэсэн халамж	25.9	65.4	15.1	79.4	58.3	121.4
Ихэр хүүхдийн тэтгэмж	3.6	8.4	2.0	12.0	55.6	142.9
АДЗГ урамшуулал	-	-	-	1.6	-	-
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	4.0	1.2	4.8	-	120.0
Насны хишиг	0.9	251.9	1.0	264.4	111.1	105.0

*-дахин их


Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 464 хүнд 909.0 сая төгрөгийн тэтгэвэр, 394 хүнд 903.2 сая төгрөгийн тэтгэмж, 282 хүнд 239.4 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 252 жирэмсэн эхэд 52.8 сая төгрөгийн тэтгэмж, 10.5 мянган хүүхдэд 7.4 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 1143 хүнд 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 368.3 сая төгрөг 1874 ахмад настанд 91.7 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 1132 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 94.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 47 иргэдэд 21.5 сая төгрөгийн хөнгөлөлт, ихэр хүүхдийн тэтгэмж 6 өрхөд 12.0 сая төгрөг, 36 хүнд амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал 1.6 сая төгрөг, 4 хүнд 4.8 сая төгрөгийн онцгой тохиолдлын тэтгэмж, 67 өрх толгойлсон эх, эцэгт 66.8 сая төгрөг тус тус олгосон байна.



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 7 сарын байдлаар 345 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 21 (6.5%) өссөн байна. Энэ хугацаанд 155.8 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 33.4 (21.4%) мянган хүнээр буурсан бол, хэвтэн эмчлүүлсэн 4.8 мянган хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 582 (12.2%) хүнээр өссөн байна.


ЗУРАГ 7. АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ, эхний VII сард



ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний VII сард

Үзүүлэлт	2022 I-VII	2023 I-VII	$\frac{2023.I-VII}{2022.I-VII}$
Амаржсан эхийн тоо	324	342	105.6
Үүнээс бусад аймгийн харьяат	79	98	124.1
Амьд төрсөн хүүхэд	324	345	106.5
Үүнээс бусад аймгийн харьяат	74	97	131.1
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	5	2	40.0

ЗУРАГ 8. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



2023 оны эхний 7 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 57 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 16.9%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 32 (36.0%) тохиолдлоор буурсан бол, цочмог халдварт өвчний 281 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 83.1%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 235 (5.1 дахин их) тохиолдлоор өссөн байна. Тайлант хугацаанд ковид-19 өвчний 44 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1560 (97.3%) тохиолдлоор буурсан байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 129.9 байгаа нь өмнөх оны мөн үеэс 467.1 продицимиллээр буурсан байна.

ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний VII сард

Үзүүлэлт	2022 I-VII	2023 I-VII	Өсөлт бууралт
Нийт халдварт өвчин	1 739	382	-1 357
Бэлгийн замын халдварт өвчин	89	57	-32
Заг хүйтэн	40	32	-8
Тэмбүү	18	17	-1
Мөөгөнцөр /кандидоз/	2	-	-2
Трихомониаз	24	8	-16
Кандилом	5	-	-5
Цочмог халдварт өвчин	1 650	325	-1 325
Цусан суулга	7	11	4
Гепатит А	1	-	-1
Скарлатин	-	13	13
Салхин цэцэг	31	203	172
Сальмонеллез	-	1	1
Ковид-19	1 604	44	-1 560
Рож	1	2	1
Гар хөл амны өвчин	1	32	31
Сүрьеэ	5	19	14



ГЭМТ ХЭРЭГ

2023 оны эхний 7 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 123 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11 (8.2%) хэргээр буурсан бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 60.3 хувьтай байгаа нь өмнөх оноос 5.8 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, эхний VII сард

Хэргийн төрөл	2022 I-VII	2023 I-VII	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	134	123	-11	-8.2	100.0
Хүнийг алах	-	1	1	-	0.8
Хүний амь нас хохирсон	5	1	-4	-80.0	0.8
Хүчиндэх	3	3	0	0.0	2.4


Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	61	54	-7	-11.5	43.9
Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг	-	1	1	-	0.8
Бусдын эд хөрөнгө хулгайлах	25	15	-10	-40.0	12.2
Залилан мэхлэх	15	24	9	60.0	19.5
Дээрэмдэх	4	2	-2	-50.0	1.6
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	1	-	-1	-100.0	0.0
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	8	4	-4	-50.0	3.3
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	1	2	1	100.0	1.6
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	7	7	0	0.0	5.7
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	4	2	-2	-50.0	1.6
Хууль бусаар ан агнах	-	1	1	-	0.8
Хуурамч бичиг баримт үйлдэх	-	3	3	-	2.4
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	-	2	2	-	1.6
Мал хулгайлах	-	1	1	-	0.8
Хэрэг илрүүлэлтийн хувь	54.5	60.3			

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 54 (43.9%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 24 (19.5%) нь залилан мэхлэх хэргүүд байна. Тайлант хугацаанд хүнийг алах болон бусдын амь нас хохирсон хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн хэрэг тус бүр 1 (2.4%) бүртгэгдсэн бөгөөд бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг 15 (12.2%), тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэрэг 7 (5.7%), хуурамч бичиг баримт үйлдэх, хүчиндэх хэрэг тус бүр 3 (4.8%), дээрэмдэх, хууль сахиулагчийг эсэргүүцэх, мөрийтэй тоглоом зохион байгуулах хэрэг тус бүр 2 (4.8%), хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших 4 (3.3%) тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 10. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР, эхний VII сард

Хэргийн төрөл	2022 I-VII	2023 I-VII	Дүнд эзлэх хувь
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	134	123	100.0
Гэр, орон сууцанд	60	46	37.4
Гудамж талбайд	22	13	10.6
Олон нийтийн газарт	8	18	14.6
Аж ахуйн нэгж, байгууллагад	13	16	13.0
Автозамд	26	7	5.7
Бусад	5	23	18.7

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг төрлөөр нь авч үзэхэд 46 (37.4%) нь гэр, орон сууцанд, 13 (10.6%) гудамж талбайд, 18 (14.6%) нь олон нийтийн газарт, 16 (13.0%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 7 (5.7%) нь автозамд, үлдсэн хэсэг нь буюу 23 нь (18.7%) бусад газарт тус тус үйлдэгдсэн байна.

ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний VII сард



ЗУРАГ 12. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эхний VII сард




ХҮСНЭГТ 10. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, эхний VII сард

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2022 I-VII	2023 I-VII	тоо	Хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	83	82	-1	-1.2
Үүнээс: эмэгтэйчүүд	10	12	2	20.0
хүүхэд	1	1	0	0.0
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	135	118	-17	-12.6
Үүнээс: нас барсан	7	2	-5	-71.4
гэмтсэн	68	61	-7	-10.3
Эрүүлжигдсэн хүний тоо	407	433	26	6.4
Баривчлагдсан хүний тоо	106	82	-24	-22.6
Учирсан хохирол /сая төгрөг/	171.8	287.2	115.4	67.2
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	80.1	175.6	95.5	119.2

*-дахин их

ЗУРАГ 13. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, эхний VII сард



2023 оны эхний 7 сард 82 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 12 (14.6%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд 118 иргэн гэмт хэргийн улмаас хохирсон ба 2 иргэний амь нас хохирч, 61 иргэн гэмтсэн байна. Мөн 433 иргэн согтуугаар зөрчил гарган саатуулагдаж, 82 иргэн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн иргэд 26 (6.4%)-аар өсч, баривчлагдсан иргэд 24 (22.6%) иргэнээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 287.2 сая төгрөгийн хохирол учирсны 175.6 (61.1%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.




ҮНЭ ХАНШ

2023 оны 7 сарын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


ХҮСНЭГТ 11. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, VII сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжих нэгж	7.07	7.14	7.21	7.28
"Алтан тариа" гурил	Дээд	кг	2 800	2 800	2 850	2 800
	I зэрэг	кг	2 250	2 600	2 500	2 500
	II зэрэг	кг	1 800	1 700	1 700	1 800
Будаа	цагаан	кг	3 600	3 800	3 800	3 950
	шар	кг	2 600	2 600	2 500	2 600
Хонины мах	ястай	кг	14 000	13 500	13 000	12 000
	цул	кг	16 500	15 500	15 000	14 500
Үхрийн мах	ястай	кг	14 500	15 500	16 000	15 000
	цул	кг	19 000	18 000	18 000	17 000
Адууны мах, ястай		кг	12 500	12 500	12 000	12 000
Ямааны мах		кг	12 000	12 000	9 500	8 500
Элсэн чихэр		кг	4 300	4 500	4 600	4 500
Сүү /задгай/		л	2 000	2 000	2 000	2 000
Тараг /задгай/		л	2 500	2 500	2 500	2 500
Цэцгийн тос, Орос		кг	6 050	6 050	6 000	6 050
Байцаа		кг	2 200	2 500	2 200	2 200
Манжин		кг	3 500	3 000	3 200	3 000
Төмс	монгол	кг	1 450	1 400	1 400	1 450
Лууван	монгол	кг	1 600	1 600	1 600	1 600
Сонгино	хятад	кг	2 200	2 200	2 200	2 200
	монгол	кг	3 000	3 000	3 000	3 000
Сармис, булцуу		ш	830	830	830	830
Огурцы, хятад		кг	5 000	5 000	4 500	4 000
Помидор, хятад /үрлэн/		кг	8 000	7 500	7 500	7 000
Ургамлын тос/ siesta/		ш	13 100	13 100	13 100	13 100
Өндөг		ш	450	450	450	450
Атар талх		ш	2 200	2 200	2 200	2 200

ЗУРАГ 14. “АЛТАН ТАРИА” ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VII сард



ЗУРАГ 15. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VII сард



ХҮСНЭГТ 12. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
• Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	110.5
• Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	130.3
2 тарифт тоолууртай		
• Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	116.4
• Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	89.2
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
• Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг	төг/квт.ц	164.0
• Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас их хэрэглээг	төг/квт.ц	187.0
3 тарифт тоолууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
• Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	164.0
• Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	256.0

• Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	105.0
3 тарифт тоолууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
• Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	187.0
• Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	291.0
• Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	121.0

* 2019 оны 3 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй айл өрхөд борлуулах тариф

*2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс мөрдөж буй үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад борлуулах тариф

ХҮСНЭГТ 13. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)	
Дулаан	1м ²	660	1м ³	1260	
Дулааны суурь тариф	40м ² хүртэл	3 000			
	41м ² - 80м ²	5 000	-	-	
	81м ² -аас дээш	10 000			
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)	1 гкал	84 272	
		1м ³ (тоолууртай)			3 162
	Зун	1 хүн (тоолуургүй)			1 632
		1м ³ (тоолууртай)			4 428
Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0	
	1 л (тоолууртай)	1.5			
	Ус түгээх байраар	2.72			1 л (зөөврөөр)
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0	
	1 л (тоолууртай)	1.5			
	Ус соруулах	15.0			

* 2023 оны 7 сарын 20-ны өдрөөс мөрдөж буй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад цэвэр, бохир усны борлуулах тариф

ХҮСНЭГТ 14. МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

	2019 VII	2020 VII	2021 VII	2022 VII	2023 VII
	төгрөг				
Адууны шир	5 000	7 000	6 500	5 000	5 000
Үхрийн шир /2.3 метрээс доош/	3 000	5 000	3 000	3 000	3 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	10 000	11 000	7 500	3 000	6 000
Хонины арьс	500	500	1 500	-	-

ХҮСНЭГТ 15. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

Шатахууны нэр төрөл	2019 VII	2020 VII	2021 VII	2022 VII	2023 VII
	төгрөг				
АИ -76,80	1 850	1 400	1 450	2 400	2 420
АИ -92	1 960	1 420	2 070	2 440	2 440
Дизель түлш	2 430	2 050	2 180	3 740	3 590

2023 оны 7 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин өмнөх онтой ижил түвшинд, дизель түлш 150 (4.0%) төгрөгөөр буурсан бол, АИ-80 бензин 20 (0.8%) төгрөгөөр өссөн байна.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2023 оны эхний 7 сард 117.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 31.2 (36.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, эхний VII сард


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2022 I-VII	2023 I-VII	<u>2023.I-VII</u> 2022.I-VII	2022 I-VII	2023 I-VII	<u>2023.I-VII</u> 2022.I-VII
Бүгд					85 827.4	117 003.0	31 175.6
Нүүрс олборлолт	м.тн	2 435.8	2 569.5	133.7	81 597.6	111 285.1	29 687.5
Дулаан дамжуулалт	м.гкал	93.2	102.2	9.0	3 405.0	4 600.9	1 195.9
Талх, нарийн боов	тн	154.2	130.3	-23.9	470.1	554.6	84.5
Зайлуулсан хог хаягдал	м.м3	29.3	27.6	-1.7	354.7	562.4	207.7

ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар




Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 133.7 (5.5%) мянган тонноор буюу 29.7 (36.4%) тэрбум төгрөгөөр, дулаан үйлдвэрлэлт 9.0 (9.6%) мянган гкал-аар буюу 1.2 (35.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Мөн талх, нарийн боовны үйлдвэрлэлт өнгөрсөн оноос биет хэмжээгээр 23.9 (15.5%) тонноор буурч, үнийн дүнгээр 84.5 (18.06%) сая төгрөгөөр нэмэгдсэн бол зайлуулсан хог хаягдлын хэмжээ 27.6 мянган метр куб болсон нь өмнөх оны мөн үеэс 1.7 (5.8%) мянган метр куб-ээр буурсан үзүүлэлт юм.

ЗУРАГ 17. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар



ЗУРАГ 18. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, мянган тонн, жил бүрийн эхний 7 сард



НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 1.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 233.2 (14.8%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 714.2 (39.6%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

ХҮСНЭГТ 17. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний VII сард

Үзүүлэлт	2022 I-VII	2023 I-VII	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	1 571.9	1 805.1	233.2
Орон сууц	389.9	389.0	-0.9
Ус борлуулалт, бүгд	586.8	714.3	127.5
Хүн амд	258.6	325.2	66.6
Аж ахуйн нэгжид	328.2	389.1	60.9
Сувагжуулалт	532.7	600.3	67.6
Бусад	62.5	101.5	39.0

ЗУРАГ 19. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөг



ХҮСНЭГТ 18. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний VII сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	403 194.4	349 037.5	98.3
Тавлаг өргөө	72 446.5	67 369.3	109.3
Маргад өргөө	73 700.2	62 161.4	93.2
Сод хөгжил	83 186.6	85 713.0	98.6
Шинэ элч	76 981.8	63 404.2	106.7
Уурхайчин	48 300.0	39 900.0	80.8
Содон суварга	48 579.3	30 489.6	92.4

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2023 оны 8 дугаар сарын 15

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛОМ 

Валютын ханш 



©2017

аппликейшнаас

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn